Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# "ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ" ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 03 — Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилт от түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1.** Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүлж, иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. НХТЖҮЧ-9.1.1, НЗДҮАХ-1.1.1, 1.1.2 | | | | | | | |
| **Зорилт 1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 1.1 | "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулах. | - | Батлагдсан төлөвлөгөөний тоо | - | 2 | "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" нь:<br>2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Монгол Улсын Засгийн газраар хэлэлцүүлэгдэж Монгол Улсын Их хуралд өргөн барихаар дэмжигдсэн.<br>2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Барилга хөгжлийн төвтэй УБХЕТ-2040 төсөлд магадлал хийлгэх ажлын гэрээг байгуулан, экспертүүдээс засвар өөрчлөлтийг авч оруулан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр улсын магадлалаар батлуулсан. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар УБХЕТ-2040 төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхийг дэмжсэн.<br>2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны дэд ажлын хэсэг байгуулагдаж УБХЕТ-2040 өргөн барьсан материалд засварыг оруулах чиглэл авч, холбогдох саналыг нэгтгэж оновчтой саналыг тусган сайжруулах ажлыг УИХ-ын зөвлөх ажлын хэсгийн оролцоотой хийсэн.<br>2025 ны 02 дугаар сарын 20-ноос эхлэн УБХЕТ-2040 төслийг дүүргүүдэд танилцуулж эхэлсэн.<br>"Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" нь "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" батлагдсаны дараа Монгол Улсын Засгийн газраар батлагдана. | |
| 1.2 | Дээд шатны байгууллагаас /УИХ, Засгийн газар, Ерөнхий сайд/ гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж, үүрэг даалгаврыг зохион байгуулж, зураг төслийн баримт бичгийг тогтоосон хугацаанд захиалагчид хүлээлгэн өгөх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Засгийн газрын хэрэг эрхэх газрын даргын Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх гэрээний хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг гарган албан бичгээр НЗДТГ-ын НБТГ, ТЗУГ-т тайлагнан ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2.** Улаанбаатар “20 минутын хот” стандарт. Улаанбаатар хотын дагуул хотуудад эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлж, төвлөрлийг сааруулна. НХТЖҮЧ-9.1.1, НХТ-1.1 | | | | | | | |
| **Зорилт 2. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 2.1 | Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулах. | - | Батлагдсан баримт бичиг | - | 1 | “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" Монгол Улсын Их хурлаар батлагдсаны дараа Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг шинэчлэн боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. | - |
| 2.2 | Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд чиг үүргийн хүрээнд ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | 100 | Энэ ажлын хүрээнд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” -ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаврын дагуу эцсийн тайлан зураглалын материалыг ТЭЗҮ, зураг төсөв, анимейшн макетын хамт захиалагчид хүлээлгэн өгсөн. | 100 |
| 2.3 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд судалгаа мэдээллийг өгч, хамтран ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | 100 | Тус институт нь 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд албан бичгээр харилцаж судалгаа, мэдээллийг өгч хамтран ажилласан байна. | 100 |
| **Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 3.1 | Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж, ажиллах. | - | Санхүүжилтийн хуваарь, тайлангийн тоо | 12 | 12 | Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулахаар 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөр төлөвлөгөө | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарган байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг хянан ажиллаж байна. | |
| 3.2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Тогтмол | 100 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж тайлант хугацаанд буюу 2025 оны жилийн эцсийн байдлаар 9-н олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, 5 зохиогчийн хяналтын үйл ажиллагаанд нийт давхардсан тоогоор 314 албан хаагчид хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгч, гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. Мөн архивын улсын үзлэгтэй холбоотой архивын өрөөний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны холбогдох баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж ажилласан. | 100 |
| 3.3 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шилэн дансанд байршуулан нийтэд мэдээлэх шаардлагатай бүх төрлийн мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | Жилдээ | Байгууллагын дүрэм, үйл ажиллагааны чиглэл, бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн, хүний нөөцийн ил тод байдал зэрэг мэдээллийг байгууллагын албан ёсны https://upri.ub.gov.mn/ веб сайтад байршуулж, байгууллагын самбарын мэдээллийг тогтмол шинэчилж байна.<br>Албан ёсны www.shilendans.gov.mn цахим хаягт сар болгоны 05-ны өдөрт багтаан холбогдох санхүү, хүний нөөц болон бусад мэдээллийг оруулж нийтэд ил тод болгон ажиллаж байна.<br>Нийт 157 мэдээлэл оруулахаас 12 дугаар сарын 01-ний байдлаар 130 мэдээлэл хугацаандаа орсон байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Монгол Улсын Их хурлын 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" /2024-2030 он/ -ийн дагуу "Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын даргаар 2025 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөр"-ийг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 5 зорилт, 9 дэд бүлэгтэйгээр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01, 02, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг сар бүр Нийслэлийн засаг даргын тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 3.5 | “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Монгол Улсын Их хурлын 2023 оны 59 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" /2024-2030 он/-ийн дагуу "Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын даргаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 3 зорилт, 11 арга хэмжээтэйгээр батлуулан хэрэгжилтийг хангаж биелэлт үр дүнг тооцож ажиллаж байна. | 100 |
| 3.6 | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын | - | Үйл ажиллагааны | 100 | 100 | 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 210 хадгаламжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын зохион байгуулалтыг хангаж нөхөн бүрдүүлэлт хийх. | | хэрэгжилтийн хувь | | | нэгж хүлээн авч, данс бүртгэл хөтлөн, Баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлж, байгууллагын даргаар батлуулан ажиллаж байна. Мөн гэмтэлтэй болон техник боловсруулалт хийх шаардлагатай баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх ажлыг зохион байгуулан ажиллав. Төрийн албан хэргийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан MNS:6395:2022 стандартын дагуу байгууллагад хөтлөгдөж бий болох захирамжлалын баримт бичгүүдийг хос бичгээр хөрвүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох стандартын дагуу гүйцэтгэж, яаралтай шийдвэрлэх болон хариу шаардлагатай бүх бичгийг хяналтад авах, шийдвэрлэсэн баримтыг хяналтаас хасах, баримт бичгийн гүйцэтгэлийн явц, үр дүнг тооцох, мэдээ тайланг хугацаанд нь тайлагнаж байна. | |
| 3.7 | Төвийн нийт албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 16 сургалт , 199 албан хаагч | 100 | 2025 оны Хүний нөөцийн хөгжил, сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримт бичиг боловсруулах аргачлал" сэдэвт сургалтад 3 албан хаагч,<br><br>2025 оны 02 дугаар сарын 04-ны өдөр Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүйн сургалтад 11 албан хаагч,<br><br>2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Нийслэлийн түүх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүрэг сургалтад 5 албан хаагч,<br><br>2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Албан хэргийг хос бичгээр хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх сургалтад 2 албан хаагч,<br><br>2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сургалтын хэрэгцээ тодорхойлох анхан шатны хэлэлцүүлэгт 15 албан хаагч тус тус хамрагдсан байна.<br><br>2025 оны 09 сарын 29-нд "Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал" сургалтад 2 албан хаагч,<br><br>2025.09.11, 12-ны өдрүүдэд Сургалтын агуулга хөтөлбөр баталгаажуулах Хэлэлцүүлэгт Хүний нөөцийн мэргэжилтэн, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 09 сарын 19-нд "Монгол бичгийн цахим бичвэр" сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдав. | |
| 3.8 | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 23 албан хаагч | 100 | Хүний нөөцийн хөгжил, сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 3 бүлэг, 11 заалтайгаар байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 3.9 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих. | - | Тарьсан модны тоо | 180 мод | 70-100 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 03, 2025 оны 10 дугаар 23ны өдөр “Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ-ын албан хаагчид “Шинэ-Налайх цэцэрлэгт хүрээлэн”-н “Жуулчин” төгөлд 250ш хайлаас, миндалийг суулгаж, цэнэглэлт хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд оролцож ажилласан. | 100 |
| 3.10 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | ISO:9001 стандартад нийцүүлэн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/07 дугаар захирамжаар Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т Бүтээмжийн менежерийн орон тоог шинээр бий болгосон. Улмаар Нийслэлийн Засаг даргын 2025 оны Б/41 дүгээр захирамжаар Бүтээмжийн менежер 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс томилогдон ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.11 | Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Батлагдсан төлөвлөгөөний тоо | - | 1 | Байгууллагын даргын тушаалаар 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатараар батлуулсан. Хэрэгжилтийг 2 жил тутам тайлагнахаар ажиллаж байна. | 100 |
| 3.12 | Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Захиргааны болон үйл ажиллагааны чиглэлээр байгууллагаас боловсруулж гаргах мэдээллүүдийг төрөлжүүлэн нэн шаардлагатай статистик үзүүлэлтүүдийг гаргаж хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. | 100 |
| 3.13 | Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Тус институт нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/312 дугаар "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай захирамжаар Хяналт, мониторингийн хэлтсийг бий болгон ажиллаж байна.<br>Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх журмын төслийг боловсронгуй болгож, олон улсын үнэлгээний (KPI тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, холбогдол бүхий, цаг хугацаатай байх шинж чанарыг агуулсан) гол үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлыг хийхээр бэлтгэл ажлыг хангаан ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.14 | Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.” гэж заасантай холбогдуулан тус институт нь хуулийн хэрэгжилтийг хангаи албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулж байна. | 100 |
| 3.15 | Тайлангийн хурлыг ISO:9001 стандартад нийцүүлэн зохион байгуулна. | - | Хурлын тоо | - | 1 | Байгууллагын тайлангийн хурлыг ISO:9001 стандартад нийцүүлэн жилийн эцэс буюу 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| 3.16 | Нийслэлийн нутгийн Захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний шийдвэрийн хэрэгжилтийг хангаи үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаи ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс байгууллагад харьяалагдсан 20 үүрэг даалгаврын биелэлтийг ERP Ulaanbaatar системийн Хяналт-шинжилгээ үнэлгээ дэд системд хугацаанд нь бүрэн оруулан ажилласан. | 100 |
| 3.17 | Байгууллагын удирдах албан тушаалтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаи ажиллах. | - | Хурлын тоо | 25 | 20-25 | Байгууллагын удирдах албан тушаалтны шуурхай зөвлөгөөнийг 22 удаа зохион байгуулж 17 удаагийн өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан дараагийн шуурхай хурал дээр танилцуулан ажиллаж байна. | 100 |
| 3.18 | Байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх 2025 оны зорилтот түвшинг тодорхойлж Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх 2025 оны зорилтот түвшинг тодорхойлж 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 02 тоот тогтоолоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийслэлийн Өмчийн газраар хянуулан, Нийслэлийн Засаг даргаар батлагдсан зорилтын хэрэгжилтийг ханган ажиллах. | | | | | батлуулан Нийслэлийн Өмчийн газраар хянуулж, Нийслэлийн засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/921 дугаартай захирамжаар батлагдсан болно. Батлагдсан төсвийн дагуу 3 дугаар улирлын байдлаар орлого 8,6 тэрбум төгрөг буюу төлөвлөлтөөс 4% өссөн. Зардал орлогоо дагаад нэмэгдсэн бөгөөд нийт зарлагын хэмжээ 8,4 тэрбум буюу цэвэр ашиг 211,9 сая төг байна. | |
| 3.19 | Байгууллагын ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлж, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2024 оны нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлэн ажилласан. | 100 |
| **Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 4.1 | Уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулах талаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах. | - | Боловсруулсан ТЭЗҮ, зураг төслийн тоо | - | 1 | Монгол Улсын Сайд, 20 минутын хотын үндэсний хорооны даргын 2025 оны А/19 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370, А/1553, 2025 оны А/606 дугаар захирамжийн дагуу 20 минутын хотын бүтээн байгуулалтын төслүүдийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ ажлын багц 2 “Уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулах талаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” УТ2407100001002 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээнд өөрчлөлт орж олон түвшний уулзвар 3-н | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршилд, Гүүрэн гарц 2 байршилд хийгдэж байна. | |
| 4.2 | Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд тусгай замын автобус (BRT) нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах. | - | Боловсруулсан ТЭЗҮ, зураг төслийн тоо | - | 1 | Техник эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар 2025 оны 07 сарын 07-ны өдөр хэлэлцүүлж дэмжигдсэн. Мөн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр 160/2025 дугаартай улсын магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулсан.Эцсийн тайланг албан бичгээр болон хэвлэмэл байдлаар Нэгдсэн төслийн удирдлагын газарт хүлээлгэж өгсөн. 2025 оны 07 сарын 25-ны өдөр 01/400 дугаартай албан бичгээр хүлээлгэж өгсөн. | 100 |
| 4.3 | Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг (LRT) нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, загвар зураг төсөв боловсруулах. | - | Боловсруулсан ТЭЗҮ, зураг төслийн тоо | - | 1 | Техник эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар 2025 оны 07 сарын 07-ны өдөр хэлэлцүүлж дэмжигдсэн. Мөн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр 160/2025 дугаартай улсын магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулсан.Эцсийн тайланг албан бичгээр болон хэвлэмэл байдлаар Нэгдсэн төслийн удирдлагын газарт хүлээлгэж өгсөн. 2025 оны 07 сарын 25-ны өдөр 01/400 дугаартай албан бичгээр хүлээлгэж өгсөн. | 100 |
| 4.5 | Хан-уул дүүргийн 17-р хороо, их Монгол улсын гудамжнаас Зайсангийн гудамж хүртэлх авто замын зураг төсөл боловсруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | 100 | Зам, тээвэр хөгжлийн төвийн даргын тушаалаар эксперт томилуулан ажиллаж байгаа бөгөөд Улсын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. | |
| 4.6 | Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжийг нарны замтай 3 байршилд холбох зураг төсөл боловсруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | 100 | Ажлын даалгаварт өөрчлөлт орсон тул зураг төсвийг дахин боловсруулж, захиалагчид хүлээлгэж өгсөн. | 100 |
| 4.7 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо Нарантуул худалдааны төвийн хойноос Өгөөмөр хотхоны үерийн суваг хүртэлх авто замыг нарны замтай холбогдох холбоос замын зураг төсөл боловсруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | 100 | Зураг төсвийг даалгаврын дагуу иж бүрэн боловсруулж, захиалагчид хүлээлгэж өгсөн. | 100 |
| 4.8 | Монголын Бурхан Шашинтны төв, Гандантэгчэнлин хийдийн орчны тохижилт, гадна инженерийн шугам сүлжээ, инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын зураг төсөв боловсруулах. | - | Боловсруулсан зураг төслийн тоо | - | 1 | Ажлын зураг төсөв бүрэн дуусж захиалагчид хүлээлгэж өгсөн. | 100 |
| 4.9 | Улаанбаатар хотын музейн дотор засварын зураг төсөл боловсруулах. | - | Боловсруулсан зураг төслийн тоо | - | 1 | Улаанбаатар хотын музейн дотор засварын зураг төслийг боловсруулж дуусган магадлалын нэгдсэн дүгнэлтийн хамт захиалагчид хүлээлгэн өгсөн. | 100 |
| 4.10 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хуучин байрыг өргөтгөн шинэчлэх зураг төсөл боловсруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Энэхүү төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шийдлийг гарган хүлээлгэж өгсөн. | 100 |
| 4.11 | Шүүх эмнэлгийн орц, гарц, зам гүүрийн зураг төсөл боловсруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Гэрээний дагуу зураг төслийг боловсруулж дуусган захиалагчид хүлээлгэн өгсөн. | 100 |
| 4.11 | Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу хот байгуулалтын баримт бичиг боловсруулах. | - | Үйл ажиллагааны | - | 100 | “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийн хувь | | | 2020/43 ЕТ/20-01 дугаартай зургийн даалгаврын дагуу боловсруулж, барилга байгууламжийн зураг төслийн магадлалын нэгтгэлийн дүгнэлтийг гаргуулж, Монгол Улсын Засгийн Газраар хэлэлцүүлэн Улсын Их Хурлаар батлуулахаар өргөн барьж, хэлэлцэгдэх шатанд явж байна. | |
| 4.12 | Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл, бусад ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | -Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/559 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-тай "Нийслэл Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа лагийг хатаах, шатааж цэвэрлэх үйлдвэр байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгэж хүлээлгэж өгсөн. Гүйцэтгэл 100 хувь.<br><br>-Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламжийн эскиз зураг боловсруулах ажлыг гүйцэтгэж дуусаад захиалагч байгууллагад хүлээлгэж өгсөн. Гүйцэтгэл 100 хувь.<br><br>-Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын түр барилга байгууламжийн ТЭЗҮ боловсруулах ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгэж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Гүйцэтгэл 12 дугаар сарын 01ний байдлаар 90 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.<br><br>-Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулах төслийн ажлыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Дундын шатны тайлангийн монгол, англи хувилбаруудыг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/688 дугаартай албан бичгээр УБЗАА-д хүргүүлсэн болно. Гүйцэтгэл 12 дугаар сарын 01ний байдлаар 60 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.<br><br>-Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн барилгын (ногоон барилга) зураг төсөл боловсруулах ажил Гүйцэтгэл 80 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.<br><br>-Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил Гүйцэтгэл 100хувь<br><br>-Хавдар судлалын үндэсний II төвийн гадна тохижилтын ажлын зураг төсөв боловсруулах ажлыг дуусгаж захиалагч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад хүлээлгэж өгсөн. Гүйцэтгэл 100 хувь.<br><br>-Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилт гудамжны зүүн талд, (Ногоон байгууламж, гадна тохижилтын элементүүд бүхий спортын талбай) гадна талбайн тохижилтын зураг төсөл боловсруулах ажил Гүйцэтгэл 12 дугаар сарын 01ний байдлаар 30 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.<br><br>-Баянгол дүүрэг, 16-р хороо, Гандантэгчилэн хийдийн зүүн урд хэсгийн тохижилтын зураг төсөл боловсруулах ажил Гүйцэтгэл 12 дугаар сарын 01ний байдлаар 20 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.<br><br>-Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хороо, Найрамдлын гадна талбайн тохижилтын зураг төсөл боловсруулах ажил 12 дугаар сарын 01ний байдлаар Гүйцэтгэл 40 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.<br><br>-Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороонд байрлах "Ногоон нуур"-ын тохижилтын зураг төсөл боловсруулах ажил Гүйцэтгэл 12 дугаар сарын 01ний байдлаар 20 хувь. 12 дугаар сарын 31нд дуусгаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 4.13 | Байгууллагад хийгдсэн барилга байгууламж, тохижилтын ажлуудад зохиогчийн хяналт тавьж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/685 дугаар захирамжаар "Авто зам, замын байгууламжийн барилга, засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах" ажлыг гүйцэтгэж үр дүнг танилцуулахыг манай байгууллагад үүрэг болгосны дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай ОН2412000723/ОН2412000830 дугаар захирамжаар "Авто зам, замын байгууламжийн барилга, засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах" гэрээ байгуулан ажилласан бөгөөд зураг төслийн баримт бичгийг Улсын магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулан 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр ажил хүлээлцсэн актаар хүлээлгэн өгсөн.<br>Дээрх 23 байршлын зураг төслийн зохиогчийн хяналтын гэрээг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хяналтын инженерүүд зохиогчийн хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй байна. 12 дугаар сарын 31нд гүйцэтгэл 100 хувь болно. | 100 |
| **Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 5.1 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хандсан иргэдийн өргөдөл, гомдлыг цахим болон бусад хэлбэрээр хүлээн | - | Хэрэгжилтийн хувь | 50 өргөдөл, | 100 | Тайлант хугацаанд буюу 2025 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар тус байгууллагад иргэнээс 1 өргөдөл, 35 албан хаагчаас ирсэн өргөдлийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авч шуурхай шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх. | | | Дундаж 8.1 хоног | | хугацаанд нь шийдвэрлэж ажилласан болно. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 2 цаг 47 минут байна. | |
| 5.2 | Байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангах, төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг байршуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын албан ёсны цахим хуудсаар https://upri.ub.gov.mn дамжуулан иргэдийг мэдээллээр хангах зорилгоор төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг байршуулан ажиллаж байна. | 100 |
| 5.3 | Сул орон тооны зарыг байгууллагын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд нээлттэй зарлах. | - | Хэрэгжилтийн хувь | 157 | 100 | Институтийн http://upri.ub.gov.mn/, erp.ulaanbaatar.mn болон https://www.zangia.mn/ олон нийтийн цахим хуудаст ажлын байрны сул орон тооны мэдээллийг байршуулж, холбогдох удирдах албан тушаалтнуудад 200 анкет илгээсэн. Журмын дагуу анхан шатны болон хоёр дахь шатны шалгаруулалтыг ISO хүний нөөц сонгон шалгаруулалтын журмын дагуу гүйцэтгэж байна. | 100 |
| 5.4 | Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 527 ирсэн, 593 явсан, Дундаж 5.4 хоног | 100 | Төрийн албан хэргийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан MNS:6395:2022 стандартын дагуу байгууллагад хөтлөгдөж бий болох захирамжлалын баримт бичгүүдийг хос бичгээр хөрвүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох стандартын дагуу гүйцэтгэж, яаралтай шийдвэрлэх болон хариу шаардлагатай бичгийг хяналтад авах, шийдвэрлэсэн баримтыг хяналтаас хасах, баримт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгийн гүйцэтгэлийн явц, үр дүнг тооцох, мэдээ тайланг хугацаанд нь тайлагнаж Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn, edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг үйл ажиллагаандаа стандартын дагуу ашиглаж байна. Тайлант хугацаанд буюу 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 584 байгаагаас хариутай бичиг -126, хариугүй бичиг -458, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 98.30 хувь, явуулсан бичиг 760 байгаагаас хариутай бичиг -77, хариугүй бичиг -683, нийт явуулсан бичгийн шийдвэрлэлтийн хувь 100 байна. | |
| **Зорилт 6. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:** | | | | | | | |
| 6.1 | Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг зураг төслийн байгууллагуудтай холбоо тогтоож тодорхой зураг төслийн ажлууд дээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах боломж нөхцөлийг судалж хэрэгжилтийг зохион байгуулах. | - | Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн тоо | 2 | 2-3 | Тус институт нь БНХАУ-ын Шанхай хотын “Ногоон байгууламж, төлөвлөлтийн ерөнхий хүрээлэн” ХХК, “Зүүн Хятадын архитектур төлөвлөлт судалгааны хүрээлэн” ХХК, “Шанхай Тунжи Хот байгуулалт, төлөвлөлтийн хүрээлэн” ХХК, “Хөх хотын захиргааны инженерийн зураг төсөл, судалгааны хүрээлэн” ХХК, “Шанхай хотын хайгуул, зураг төслийн судалгааны хүрээлэн” ХХК-иудтай Хамтран ажиллах санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. | 100 |
| 6.2 | Гадаадын зочид, төлөөлөгчдийг урих, хүлээн авах арга хэмжээг зохион байгуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Тайлант хугацаанд гадаадын зочид төлөөлөгч хүлээж аваагүй болно. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.3 | Мэргэжлийн чиглэлээр зарлагдсан олон улсын уралдаан, хурал, сургалт, зөвлөгөөнд оролцох. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Оросын холбооны улсын Эрхүү хотын Зам тээврийн яамны Авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал болон төрийн бодлого хэрэгжүүлэх газартай харилцаа тогтоох ажлын хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд Эрхүү хотоор зочилж, туршлага судлах хамтын ажиллагааны талаар хийх албан уулзалтад Трамвай төсөл дээр ажиллаж буй холбогдох 7 албан хаагч хамрагдсан. Энэхүү уулзалтын хүрээнд Улаанбаатар хотод трамвай барих төслийн хүрээнд туршлага солилцож, ТЭЗҮ-г боловсруулахад анхаарах зүйлсийн талаар санал солилцож хамтран ажиллаа.<br><br>Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргаар ахлуулсан бүрэлдэхүүнд байгууллагын дарга, Ерөнхий инженер нар оролцож 2025 оны 03 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд БНХАУ-д албан томилолтоор ажилласан. Уулзалт, хурлын үеэр БНХАУ-ын Хот төлөвлөлт, ногоон байгууламж, ландшафт төлөвлөлтийн хүрээлэнгүүдтэй найрсаг харилцаа тогтоож, Улаанбаатар хотын хөгжлийг дэмжих хүрээнд ногоон байгууламж, гол болон авто зам дагуух тохижилт, зам гүүрийн бүтээн байгуулалт, 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зэрэг чиглэлд хамтран ажиллахаар Санамж бичиг байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сингапурын Олон Улсын Усны Долоо Хоног (Siww) 2025 болон Ногоон барилгын судалгааны ажлын хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үерийн эрсдэлтэй хотууд” туршлага солилцох уулзалтад АТХ-ийн архитектор, ахлах мэргэжилтэн Н.Мөнхзул оролцов.<br><br>Нийслэлийн Засаг даргын А/1255 дугаар захирамжийн "Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хурлын байр, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын дэлгэцийн систем, орчуулга ба AV шийдлүүд, дэлгэц ба үзэсгэлэнгийн тоноглолын мэдээлэл болон үнийн санал бусад мэдээллүүдийг судлах, цуглуулах, туршлага судлах ажлын хүрээнд Эдийн засгийн ахлах мэргэжилтэн Х.Долгорсүрэн, архитектор Ж.Амаржин нар 2025 оны 09 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд Гуанжоу, Фошан хотоор зочилж, туршлага судлах уулзалтад оролцов.<br><br>Бразил Улсын Белем хотод зохион байгуулагдаж буй Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын суурь конвенцын Талуудын бага хурал "Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 30 дугаар бага хурлыг Монгол улсад зохион байгуулахтай холбоотой байгууллагын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дарга Р.Амартүвшин, Ерөнхий инженер Б.Лхагвасүрэн нар оролцов. | |
| 6.4 | БНСУ-ын Сөүлийн их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд богино болон дунд хугацааны сургалт зохион байгуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр БНСУ-ын Сөүлийн их сургуультай Санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.<br>Дээрх ажлын хүрээнд Монгол Улсад тогтвортой, аюулгүй, ухаалаг, хотыг хөгжүүлэхэд хот байгуулалтын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх S-QUAD төслийн хүрээнд БНСУ-д зохион байгуулагдах гүйцэтгэх албан тушаалтны хоёрдугаар ээлжийн сургалтад Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Тэлмэн, Зам, тээвэр судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Анхбаяр нарыг бүртгүүлсэн. БНСУ-д болох Хот байгуулалтын салбарын мэргэжилтний сургалтад 2025 оны 05 сарын 19-ний өдрөөс 2025 оны 05 сарын 27-ны өдрүүдэд хамрагдсан. | 100 |
| 6.5 | Шанхай хотын ногоон байгууламж төлөвлөлтийн ерөнхий хүрээлэн ХХК, Зүүн хятадын архитектур төлөвлөлт судалгааны хүрээлэн ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, туршлага солилцох. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Тус институт нь БНХАУ-ын Шанхай хотын "Ногоон байгууламж, төлөвлөлтийн ерөнхий хүрээлэн" ХХК, "Зүүн Хятадын архитектур төлөвлөлт судалгааны хүрээлэн" ХХК, "Шанхай Тунжи Хот байгуулалт, төлөвлөлтийн хүрээлэн" ХХК, "Хөх хотын захиргааны инженерийн зураг төсөл, судалгааны хүрээлэн" ХХК, "Шанхай хотын хайгуул, зураг төслийн судалгааны хүрээлэн" ХХК-иудтай Хамтран ажиллах санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 7. Албан хаагчдыг чадавхижуулах, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалтад хамруулах ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 7.1 | Ажилд авах үеийн чиглүүлэх, дадлагажуулах сургалт. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 19 | Тухай бүрт | Тус институт нь тайлант хугацаанд шинээр болон жинхэлсэн 19 албан хаагчтай Хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Шинээр орсон ажилтнуудад байгууллагын дүрэм, журмыг танилцуулан ажиллаж байна. Мөн шинээр орсон албан тушаалтнуудыг 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр “Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй сургалт”-д, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр “Нийслэлийн түүх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүрэг сургалтад тус тус хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.2 | Нийт албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын байран дээрх богино хугацааны сургалтууд. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 5 сургалт, 159 албан хаагч | Тухай бүрт | Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын байран дээрх богино хугацааны дараах сургалтуудыг зохион байгуулав. Үүнд:<br>2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Ногоон санхүүжилт ба Эрчим хүчний хэмнэлтийн төслийн хөрөнгө оруулалт, Барилгын инженерийн системийн автомажуулалт” танхимын сургалтад 8 албан хаагч,<br>2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “Эрчим хүчний үр ашигтай барилга, түүний тодорхойлолт, тавигдах шаардлага цахим сургалтад 6 албан хаагч,<br>2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр “Барилгын эрчим хүчний хэмнэлтийг хэмжих, баталгаажуулах аргачлал мөн Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг, цахилгааны систем” танхимын сургалтад 15 албан хаагч,<br>2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр “Барилгын эрчим хүчний дүрэм, журам ба холбогдох норм, стандарт мөн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх” танхимын сургалтад 18 албан хаагч,<br>2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Дотор агаарын чанар мөн Бид юу хийх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэ, 2050 он хүртэлх Герман улсын баримтлах 10 зарчим онлайн сургалтад 20 албан хаагч,<br><br>2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Эрчим хүчний үр ашигтай халаалт агаар сэлгэлтийн систем, Эрчим хүчний үр ашигт өндөртэй хэмнэлттэй барилгын төлөвлөлт цахим сургалтад 4 албан хаагч нийт давхардсан тоогоор 71 албан хаагчийг тус тус сургалтад хамруулж ажилласан.<br><br>2025 оны 08 сарын 21, 22-ны өдрүүдэд Нийслэлийн Архивын газарт Архив бичиг хэргийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br><br>БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага \КОЙКА\-н захиалгаар Духуа инженеринг, Сөүл хотын их сургууль, БНСУ-ын барилгын технологийн судалгааны хүрээлэн, Сун-ам сискомын хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах сургуулийн бүсийн туршилт суурилуулалт болон чадавх бэхжүүлэх PMC төслийн нээлтийн хуралд ахлах мэргэжилтэн Ш.Баяржавхлан, архитектор Г.Энх-Амар нар оролцсон<br><br>-2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр ЭЗСТХ-ийн ахлах мэргэжилтэн А.Саруул нь судалгааны чиглэлээр Falling walls | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олон улсын хуралд судалгааны чиглэл Улаанбаатар хотын түүхэн орон зайг хамгаалах тухай илтгэл тавьж Гутгаар байранд шалгарсан.<br><br>2025 оны 09 дугаар сарын 18-ны өдөр судалгааны чиглэлээр Urbansketchers буюу 70 улсын 514 хотын зураг зурдаг архитекторууд, оюутнууд, судлаач нарын нэгдэлд Мэдээлэл технологийн Парк түүхэн ач холбогдол бүхий 2040 оны ХЕТ тусгагдсан шинээр дурсгалд авах барилга болон байгууллага танилцуулсан арга хэмжээнд 1 албан хаагч оролцсон. | |
| 7.3 | Албан тушаалын чиг үүргийн дагуу шаардлагатай сургалт, семинарт хамруулж мэргэшүүлэх дунд хугацааны сургалтууд. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 3 сургалт, 9 албан хаагч | Тухай бүрт | АТХ-ийн Барилгын инженер М.Нямдаваа мэргэшсэн инженерийн багц цагийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан ба шалгалтад орохоор бэлдэж байна.<br>ХТХ-ийн ахлах мэргэжилтэн Ш.Баяржавхлан нь Газар зохион байгуулагч мэргэшсэний зэргээ сунгасан.<br>Архитекторуудын мэргэшсэн зэрэг горилох, сунгах сургалтад ЭЗСХ-ийн ахлах мэргэжилтэн А.Саруул, ХТХ-ийн Архитектор Г.Энх-Амар нар хамрагдаж байна. Мөн ХДХ-ийн Архитектор Ж.Амаржин багц цагийн сургалтаа дуусгасан ба мэргэшсэний шалгалт өгөхөөр бэлдэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.4 | Хариуцсан ажил үүргийн дагуу дээд шатны байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад хамруулах. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 9 сургалт, 27 албан хаагч | Тухай бүрт | Ногоон барилгын аудитор бэлтгэх сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. | 100 |
| 7.5 | Албан хаагчдыг эзэмшсэн боловсролын түвшингээ дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалтад хамрагдах нөхцөл боломжоор хангаж, дэмжлэг үзүүлэх. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 1 сургалт, 1 албан хаагч | Тухай бүрт | “Барилгын эрчим хүчний хэмнэлтийн ашиг 3 багц сургалтад 20 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.<br>Барилгын инженерүүдийн холбооноос зохион байгуулдаг “Барилга байгууламжийн бүтээцийн зураг 1.7 хүрээ”-ний мэргэшсэн зэрэг горилох инженерүүдэд зориулсан 3 багц цагийн сургалтад 1 албан хаагч амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан. | 100 |
| 7.6 | Нийт албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | Анхан, дунд тус бүр 24 | Тухай бүрт | 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Албан хэргийг хос бичгээр хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх сургалтад 2 албан хаагч, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Монгол бичгийн цахим бичвэр сургалтад 2 албан хаагчийг тус тус хамруулсан. | 100 |
| **Зорилт 8. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 8.1 | Ажилласан ажлын өдрөөр тооцон хоол, унааны нэмэгдлийг олгох. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагад мөрдөгдөж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний баримт бичиг MNS ISO9001:2015-ын “Цаг ашиглалтын журам”-ын дагуу нийт ажилчдын цагийн тооцоог үндэслэн ажилласан өдрөөр нь тооцон хоол, унааны нэмэгдлийг олгож байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.2 | Ажлын үр бүтээл, түүний чанар, идэвх зүтгэлийг харгалзан үзэж үр дүн, ур чадварын нэмэгдэл, шагнал, урамшуулал зэргийг мөнгөн хэлбэрээр олгох. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагад мөрдөгдөж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний баримт бичиг MNS ISO9001:2015-ын "Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх" 27 дугаар журмын дагуу тооцон ажиллаж байна. | 100 |
| 8.3 | Үүрэгт ажилдаа идэвх зүтгэл гаргаж үр бүтээлтэй ажиллаж, шинийг санаачилсан албан хаагчдыг байгууллагын, Нийслэлийн, салбарын болон төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлох. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Тэмдэглэлт ойн баяруудыг тохиолдуулан идэвх зүтгэл гаргаж үр бүтээлтэй ажиллаж, шинийг санаачилсан албан хаагчдыг байгууллагын, Нийслэлийн, салбарын болон төрийн дээд шагналд тодорхойлохоор материалыг нь хүргүүлсэн болно. | 100 |
| 8.4 | Хамт олны уур амьсгалыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэлтэс, хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор олон нийтийг хамарсан үйл ажиллагаануудыг зохион байгуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Тайлант хугацаанд албан хаагчдын эрүүл мэнд, чийрэгжүүлэлттэй холбоотой дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:<br>- 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр тогтмол авдаг спорт заалны 2 цагтаа багтаан хэлтсүүдийн хооронд волейболын тэмцээнийг спорт хамтлагтай хамтарч зохион байгуулсан,<br>- Байгууллагын Боулингийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан,<br>- 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр байгууллагын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Мөн түүнчлэн өдөр бүр тогтмол 15 минутын ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зохион байгуулан ажиллаж байна.<br>- 2025 оны 09 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд Монгол Улсад орчин цагийн барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жил, Нийслэлийн орон сууцны корпораци ХК байгуулагдсаны 10 жилийн ойн хүрээнд барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд болон төслийн нэгжүүдийн дунд Спортын зургаан төрөлт наадмыг амжилттай оролцсон. | |
| 8.5 | Инженер, техникийн болон албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай нормын хувцас хэрэгслээр хангах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хөдөлмөр аюулгүй байдлын ажилтантай хамтран байгууллагын стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг хангаан инженер, техникийн болон албан хаагчдыг ажил үүргээ аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэн шаардлагатай нормын хувцас хэрэгслээр хангаан ажиллаж байна. | 100 |
| 8.6 | Албан хаагчдыг шаардлага, стандартад нийцсэн, тав тухтай ажлын байр болон ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, баримт бичиг, бусад зүйлээр хангаж сэтгэл ханамжтай ажиллах орчин, нөхцөл, боломжоор хангах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хэлтэс бүрийн шаардлагатай бичиг баримт болон хангамжийн материал (цаас, хавтас, нуруу, хор, тэмдэглэгээний цаас г.м)-аар тогтмол хангаан, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл, лицензтэй программуудыг худалдан авч, ажилтнуудыг бүрэн хамруулан, ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, тогтвортой үр дүн гаргах нөхцөл боломжийг ханган ажиллаж байна. | |
| 8.7 | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга авах. | - | Авсан санал асуулгын тоо | 1 | 4 | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны 3 дугаар улиралд нийт албан хаагчдаас авсан. | 100 |
| 8.8 | Албан хаагчдын гэр бүлийг дэмжин шинээр гэр бүл болох, шинээр хүүхэд төрөх, мэргэжил дээшлүүлэх, үргэлжлүүлэн суралцах, олон улсын тэмцээн уралдаанд оролцох, эрүүл мэндийн байдал муудах, ар гэрийн гачигдал зэргийг харгалзан үзэж цалинтай чөлөө болон нэг удаагийн буцалтгүй тусламж олгох. | - | Тусламж олгосон албан хаагчдын тоо | 23 | Тухай бүрт | Байгууллагын жил бүрийн бизнес төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж, батлуулан батлагдсан зардлын дагуу тайлант хугацаанд шинээр 3 хүүхэд төрсөн, 16 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгож, давхардсан тоогоор 11 албан хаагчид цалинтай чөлөө олгосон байна. | 100 |
| 8.9 | Гэр болон ердийн галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс, шахмал түлш худалдан авахад нь зориулж жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх. | - | Тусламж олгосон албан хаагчдын тоо | - | Тухай бүрт | Гэр болон ердийн галлагаатай байшинд амьдардаг албан хаагч байхгүй болно. | 100 |
| 8.10 | Албан хаагчдын 16-аас доош насны хүүхдүүдэд зориулсан олон нийтийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын 83 хүүхдэд хүндэтгэл үзүүлсэн. | 100 |
| 8.11 | Төвийн ахмад настан, 50-аас дээш насны албан хаагчдад Цагаан сар болон Ахмадын өдрөөр хүндэтгэл үзүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Арвандолдугаар жарны Элдэв эрдэнэт хэмээх модон могой жилийн цагаан сараар байгууллагын 26 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.12 | Тухайн жилд 50, 60 нас хүрсэн албан хаагчдад хүндэтгэл үзүүлэх болон тэтгэвэрт гарч байгаа албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | 2025 онд тэтгэвэрт гарах албан хаагч байхгүй болно. | 100 |
| **Нийт дундаж хувь:** | | | | | | | **99** |

*Төлөвлөгөөг хянасан:*

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч

................................
*(гарын үсэг)*

**_Төсвийн Ерөнхийлөн захирагч_**

Х.НЯМБААТАР

............................
*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:*

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

................................
*(гарын үсэг)*

ТҮ31925 9020010718 5369568

**_Төсвийн Шууд захирагч_**

Р.АМАРТҮВШИН

...............................
*(огноо)*